



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/138

Улаанбаатар хот

Хонины цэцэг өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/951 дүгээр захирамж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/275 дугаар тушаал, Нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/75 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг дүүргийн хэмжээнд 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ны өдрийн хугацаанд шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

2.Гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус дүүргийн өвчинд мэдрэмтгий нийт 17200 толгой мал, амьтныг вакцинжуулалтад бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ трейд" ХХК (А.Цэрэндагва)-д, вакцинжуулалт хийгдэх товлосон хугацаанд, малчдад зар хүргэж, мал, амьтнаа бэлэн байлгах ажлыг зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зүү тариур халдвар хамгаалал, хөдөлмөр хамгаалал, шатах тослох материал, ажиллах хүн хүчний зардлыг хавсралтаар баталсугай.

4.Гоц халдварт өвчний дархлаажуулалтад шаардагдах 2,161,200 (Хоёр сая нэг зуун жаран нэгэн мянга хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2024 он ажил захирамж

1123200533

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 08 сарын 21-ны өдрийн 1138 дугаар
захирамжийн хавсралт



ХОНИНЫ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТАД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

ЗАРДЛЫН ТООЦОО-ШАТАХУУН

№	Аж ахуйн нэгжийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун	л	240	2410	578400
2	Тариур	ш	500	400	200000
3	Зүү	ш	600	700	420000
4	Нэг удаагийн бээлий	Хайрцаг	2	35000	70000
5	Шатахуун А-92 вакцин татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалт	ш	80	2410	192800
Нийт дүн					1.461.200

АЖИЛЛАХ ХҮН ХҮЧ

№	Ажиллах хүч	Тоо	Хүн өдрийн цалин	Нэг өдрийн нийт цалин	Ажиллах хоног	Нийт
1	Туслах ажилтан	2	50000	100000	7	700000
Дүн						700000
Нийт дүн						2.161.200